

Утга эсрэгцсэн зүйр цэцэн үг"-ийн шүлэглэх хэв маягт хийсэн судалгаа

*Na Ren Ge Ri Le,
ӨМӨЗО-ны Хөххотын үндэсний туршилтын сургууль*

Хураангуй

Зүйр цэцэн үг нь дан ганц утга санааг, туулийн хөдөлшгүй байдлаар илэрхийлэх боломжгүй учир хувь хүн бүрийн амьдралын туршлага харилцан адилгүй учраас тэдгээр хүмүүсийн амьдралыг үзэх үзэл, өөр өөр байдаг. Хорвоо ертөнцөд олон зүйлсийн утга санаа сайн-муу, сайхан-муухай, хар-цагаан, зөв-буруу, үнэн-худал гэх амьдралын адил бус шүтэлцээнд оршиж байдаг. Эдгээрийн үнэн худлыг нотлох нотолгоо бүр ижил байх албагүй, яг хоёр тууль мэт. Тэдгээр хоёр утга санааг илтгэх хэлний урлаг нь “утга эсрэгцсэн зүйр цэцэн үг” юм. Утга эсрэгцсэн зүйр үг нь өөрийн болон өрөөл бусдын амьдралд тохиолдсон үйл явдал, учир шалтгаант байдалд туулийн оновчтой байдлаар зөвлөгөө өгөх логик утга санаа болж байдаг тул учир шалтгаант, утга эсрэгцсэн зүйр үгсийн утга санааг ухамсарлах, яагаад утга эсрэгцсэн зүйр үг үүсдэг шалтгаан, шүлэглэх хэлбэр зэргийн шүтэлцээг ойлгуулах аргазүйн асуудлын талаарх судалгааны үр дүнг танилцуулах зорилгоор энэхүү өгүүллийг бичсэн болно.

Түлхүүр үг

Утга эсрэгцсэн зүйр үг, үнэт зүйлс, хэл, соёл сэтгэлгээ, зүйр үг

Удиртгал.

Түүхийн бүхий л цаг үеийн соёлын орчныг даван туулсан хүн төрөлхтөн өөр өөрийн гэсэн түүхэн дурсамж, дурдатгал, амьдралын туршлагыг бий болгож, өөр өөрийнхөө “үзэл бодлын хамгаалагч” болж байв. Энэ үзэл бодлыг илэрхийлэгч зүйлс нь монголчуудын аман ярианы соёлын орчинд амаас ам дамжиж ирсэн амьдралыг зүйрлэн, үлгэрлэн, утгачилж өгүүлэх “зүйр цэцэн” үг юм. Зүйр цэцэн үгийг “юм үзэгдэл, үйл явцын шинж төлөвийн төсөөт байдлаар нь утга шилжүүлэн хэрэглэх /үүнийг Зүйрлэл (metaphor, metaphore/ ”(Ж. Баянсан III. Одонтөр. 2004. х-169) явдал гэж ойлгоно. “Хүмүүс метафорыг хүн төрөлхтөн болон хүний оюун ухааны оньсого гэж үздэг. “Метафор” гэх үг нь утга шилжүүлэх гэсэн утгатай “metapherein” гэх герег үгээс гаралтай. Метафор нь тодорхой юм үзэгдэл, үйлийн шинж чанар, онцлог зэргийг оноон тэмдэглэсэн үгийн өөр бүлэг юм. Үзэгдэл, үйлийг тодорхойлоход шилжүүлэн хэрэглэх хэлэхүйн үйлдлийг “metapherein” гэнэ. (Э. Равдан. 2000. х-133) Эрдэмтэн С. Дулам, Ц. Хасбаатар нар: “Хэлний аливаа үгс өөр хоорондоо холбогдож нэгдэхдээ цоо шинэ утга чанартай болж, уран сайхны дүрийн баялаг бололцоог бий болгож байдаг. Уран зохиолын хэлний үгсийн санд ихээхэн тохиолддог үгийн чухал нэг чанар бол салаа утга бөгөөд юм үзэгдлийг аль болох тодорхой, амьд дүрслэхэд зохиолчдод хэрэг

болдог зүйл юм”, гэх мэт эрдэмтдийн судалгаанаас ажиглахад: зүйр цэцэн үг нь ерөнхийдөө аливаа зүйлийн шилжсэн утга санааг холбоо үгээр илэрхийлэх, эсрэг утгатай үгсийг хоршуулан хэрэглэх шүлэглэлт үгсийг хэлж байна. Энэ мэт зүйр цэцэн үгсийн шинж онцлогийг нарийвчлан судлан үзвээс утга эсрэгцсэн зүйр үгсийн үндсэн онцлог шинжийг тодруулах чухал ач холбогдолтой хэмээн үзэж: үнэт зүйлсийн өөрчлөлт ба утга эсрэгцсэн зүйр үг, “утга эсрэгцсэн зүйр цэцэн үг”-ийн шүлэглэх хэв маяг, “утга эсрэгцсэн зүйр цэцэн үг” ийн логик утга, нийгмийн үүрэг хэрэглээ гэх гурван зүйлээр ангилан судлахыг хичээсэн болно.

Үнэт зүйлсийн өөрчлөлт ба утга эсрэгцсэн зүйр үг

Дэлхийн хүн төрөлхтнийг сэтгэлгээнийх нь нийтлэгээр өрнийн болон дорнын гэж ерөнхийлөн ангилдаг. “Дорно дахин нь сэтгэцийн бодит байдал дээр, өөрөөр хэлбэл оршихуйн гол, цорын ганц нөхцөл гэж болох сэтгэл санаан дээр суурилдаг. Дорно дахины сэтгэл санааг зөвшөөрч буй байдлыг философийн бодол санааны үр дүн гэхээсээ сэтгэл зүйн баримт буюу зан авирын илрэл гэмээр. Яагаад гэвэл өрнөдийнхнөөс эрс өөр интроверт шинж дорнынхонд давамгайлдаг.” (К. Г. Юнг, 2011.х-380) Зүйр цэцэн үгэнд ч энэ шинж “эрдэмтэй хүн даруу, их мөрөн дөлгөөн”

55696190@qq.com

гэх мэтээр илэрсэн байна. Энэ нь монголчууд “интроверт” шинжтэйн баталгаа. Аливаа зүйлийг өөрийн үзэл бодол, туршлагат амьдралын хэв маягаар тайлбарлах, хувь хүний үнэлэмжээс үүдэн, үнэт зүйлийн мөн чанар хувьсан өөрчлөгдөж байдаг. Тухайлбал:

“Ерөөлчийн хүүхэд ерөөлч

Хараалчийн хүүхэд хараалч”

гэдэг зүйр үг нь генетивтийн зөв утга, удамшлынх нь хувьд авьяас билиг удам дамжих, уламжлан сургах, сурах үйлүүдийг зааж эх нь шийр алаг бол хүү нь шийр алаг хэмээх удмын сангийн асуудлыг хөндөж буй бол яг үүний эсрэг утга агуулсан зүйр үг нь:

“Дуудах нэрийг эцэг эх

Дуурсах алдрыг өөрөө олох”

зүйр үг нь эзэн биений ганц бие, бие даасан шинж онцлого, хувь хүний амьдралын туршлага, орчин ахуй, цаг үе, үзэл сэтгэлгээ, сэтгэхүйн ялгаатай байдал нь эцэг эхтэй адилгүй байх боломж бололцоог илтгэж буй зүйрлэл юм. Энэхүү хоёр дахь зүйр үг бол чухамдаа оршихуйн үндэсийг зааж байна. Хүн бол өөрөө байгаа нь оршихуй биш бусад нь оршиж байгаа учраас бие хүн оршиж байна гэх харилцаанаас үүссэн оршихуйг хэлж буй юм. “Аливаа нэг юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг өөр өөр үндэстэн ястнууд харилцан адилгүй хэлэндээ нэрлэн тэмдэглэснээс гадна түүнийг тус бүр өөр өөр утгаар илэрхийлсэн байдаг нь олон”(Ц. Өлзийхутаг. 1979. х-34) Энэ нь тухайн улс үндэстний эртнээс аж төрж ирсэн нутаг орон, байгалийн байдал, ахуй, амьдралын хэв маяг, ёс заншил, шашин шүтлэг зэргийн онцлогоос үүдэж, үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдлыг үнэлэх үнэлэмжийн жишиг хэмжүүр /эталон/ бий болсонтой холбоотой /Монгол хүн их бие сайтай хүнийг “чулуу” шиг гэдэг бол Орос хүн “бух” шиг гэдэг/. Нүүдлийн иргэншил нь мал аж ахуйгаас шалтгаалан харьцангуй хамтын шинжтэй байдаг. Нүүдэлчдэд “Айлын хоол амттай, Аяны цай шимтэй”, “Айл хүний амь нэг, хөрш хүний хөвөө нэг”, “Ганц цуцал гал болохгүй, Ганц хүн айл болохгүй” зэрэг үгс нь эерэг үнэлэмжтэй. Харин суурин амьдрагчдад “индивидуалист”, “эгоист” чанар давамгайлдаг тул дээрх үгс үнэ цэнтэй биш байдаг. Монгол улс дотроо “хөдөөнийхөн”, “хотынхон” гэсэн соёлын нийтлэгт хуваагдана. Монгол хүний язгуур үнэт зүйлсийг нүүдлийн соёл иргэншил тээсээр өдгөө хүрч, хэл, сэтгэлгээнд дархлаажсан боловч суурин соёл иргэншлийн хэт задгайрсан тархи, шинэ үнэт зүйлснүүд монгол сэтгэлгээ рүү эрээ цээргүй дайрч давшилсаар байна. “Аливаа улс гүрэн, үндэстэн ястан өөрийн

язгуур соёл, оршихуйн суурь уламжлалаа танин мэдэж, ойлгон ухамсарлахгүйгээр өнөө цагийн хэт иргэншил дунд сүлд оюуныхаа /geistiswissenschaften/ бие даасан тусгаар байдлыг хадгалан үлдэх бололцоогүй” (С. Энхбаяр. 2008. х-145) болдог нь махан бие нь л монгол болохоос, сэтгэлгээ нь харь хахь болж, хувийнхаа үнэт зүйлийг үндэстний үнэт зүйлээс илүүд бодогсод, тэдгээрийн өдөр тутмын ярианы хэлний болхи бүдүүлэг байдал, хагас хугас гадаад хэлээр чамирхахаас ч эхэлдэг байж болох юм. Тиймээс ч бидний монголчууд нь “гарал үүсэл, хүрээлэн буй орчин нөхцөл, угсаатны зүй, амьдралын хэв шинж, нийгэмшлийн өвөрмөц дүр төрх, түүхэн хувь заяаны замнал зэргээрээ хоорондоо эрс ялгаатай дээрх хоёр том бүхэллэг нь ухамсар, оюун санаа, үнэт зүйлс, сэтгэлгээний хувьд ч мөн л хоорондоо эрс ялгаа бүхий хоёр өөр загварыг бий болгожээ” (С. Энхбаяр. 2008. х-148). Иймээс газар газрын ястан бүрийн зүйрлэлүүдэд нэг нөгөөгөө шүүмжилсэн, шоглосон шинжтэй зүйрлэлүүд ч байдаг. Гэвч эдгээр зүйрлэл нь нийгэмд сөрөг үнэлэмжийг бий болгодог тул энд өгүүлэх нь зүйд бус нийцнэ. Хүн хаана, хэзээ, хэнийд төрж, яаж өссөнөөсөө хамааран ертөнцийг яг тийм байдлаар хүлээн авч тус бүрийн соёлын орчныг бүрэлдүүлж, үгсийн сангийн хувьд, үлгэрлэл, зүйрлэлийн хувьд ч ондоошиж, ижилсэж гэх мэтээр үргэлжийн хөдөлгөөнт байдалд хэл сэтгэхүй хувьсан өөрчлөгдсөөр байгаа нь дээр эш үндэс авсан утга эсрэгцсэн зүйрлэлүүдийн утга санаасаас бүрнээ ажиглагдаж байна.

“Утга эсрэгцсэн зүйр цэцэн үг”-ийн логик утга, нийгмийн үүрэг хэрэглээ

Зүйр цэцэн үгийн бүтэх гол арга бол зүйрлэл /метафор/. Зүйрлэл нь тухайн ард түмний оюун билэг, аж төрөл, ахуй амьдралаас үүдэн гарсан өвөрмөц сэтгэхүйг тусгадаг бөгөөд бодит амьдралын юм, үзэгдэл хоорондын харьцааг танин мэдэхэд чухал ач холбогдолтой. Өвөрмөц хэллэг, зүйр, цэцэн үг зэрэг тогтвортой хэллэг нь биеэ даасан нэгж юм. (Ж. Баянсан. 2002.х- 45) Метафор бол зөвхөн хэлний үзэгдэл биш, ертөнцийг таньж мэдэх чухал арга барил. Хүн төрөлхтний сэтгэхүйн хэлбэр нь зүйрлэлт шинжтэй байж, нэгэнт мэдсэн ухагдахууныг ашиглаж, өөр танин мэдэхүйн орчин дахь шинэ ухагдахууныг адилтган зүйрлэж, танин мэдэж, орлуулан илтгэх чадвартай байдаг. Энэхүү явцад: хүний сэтгэхүйн чадавх, амьдралын туршлага, нийгмийн орчин болон соёл, зан араншин нөлөөлдөг. Харилцаж байгаа хүн өгүүлж байгаа юмандаа хандах хандлага, өгүүлэгчийн үнэлэмж зүйрлэлд маш тодорхой илэрсэн байдаг. Ийм

үнэлэмж нь сайн-муу, сайхан-муухай, таатай-таагүй, зохистой-зохисгүй гэх мэтээр юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар зэргийг эерэг сөргөөр эсрэгцүүлсэн байдаг. Энэ нь ертөнцийн юм үзэгдэл, хүний амьдралын үйл явдал маш олон талтай бөгөөд хүн ч өөрөө түүнийг янз бүрийн хэрэгцээний үүднээс олон талаас нь харах бололцоотой байдагтай холбоотой. Зүйрлэл нь адил төстэй хоёр үзэгдэл, ахуй амьдрал дээрээс ургаж гардаг. Юуг зүйрлэх, юутай зүйрлэн хэлэх гэх хоёр зүйлээс зүйрлэл бүтэх бөгөөд тэгэхдээ энэ хоёр зүйл ямар талаараа адил төстэй байгааг нарийн ажсан байх нь чухал. Тухайлбал: “Баян хүний ерөөл, Барлагийн чихэнд хараал” гэх зүйр үг нь: баян ядуу хоёр хүн угаас юмны хоёр тууль, сэтгэхүйн эсрэг зүйл, ухагдахуун ойлголт ондоошилд хамаарч байдаг хэмээжээ. Үүнийг баян хүнээс хандаж хэлсэн ерөөлийн үгс нь ядуу хүний чихэнд тохуурхал болж байдаг гэх санааг илэрхийлсэн зүйр үг гэж болно. Үүнийг эрдэмтэн Н. Ням-Осор, Б. Өлзийсүрэн нар: “баян хөлжүү эрхэм дээдсийн магтах гоё сайхан ерөөл нь хоосон ядуу хүнд бол хор шарыг нь хөдөлгөсөн хараал аятай сонсогдоно гэдгийг егөөдөн хэлсэн эртний үг”. (Н. Ням-Осор, Б. Өлзийсүрэн. 2011. х-72) хэмээн тайлбарлжээ. Энэ бол зүгээр нэг хэллэгийн тал биш, амьдралын хэвшил, ядуугаас баянд хүсэмжлэх хүслийн хясалт амьдралаас үүдсэн хорсол зэвүүцэлт оюун санаанд баяны ерөөлийн үгс эсрэг утгаараа хараал мэт буудаг болохыг илтгэсэн зүйрлэл болж байна. Харин баян болон ядуу хоёрын харилцан уялдааг шүтэлцүүлэн илэрхийлсэн зүйр үг нь : “Эзний төлөө гуйланч зовно, Эхнэрийн төлөө эр зовно” гэдэг зүйр үгийг / Хэчнээн ядуу гуйлгачин ч улс орныхоо төлөө зовж, сэтгэл зүрхээ зориулж явдаг гэсэн зүйрлэл. Зүйрлэлийн нөгөө нь эхнэр эр нөхрөө амар заяа үзүүлдэггүй, энэ бол эртнээс байж. (Н.Ням-Осор, Б. Өлзийсүрэн. 2011.х- 70) хэмээн тайлбарласан нь ташаарал бөгөөд “эх орон” бол хүний эзэн биш, хүн өөрөө эх орныхоо эзэн нь байж, эх орны тухай төсөөллийг өөртөө бий болгодог гэвэл илүү оновчтой болно. Уг зүйр үг захирах захирагдах ёсны тухай өгүүлж буй юм. Зүйр үгэн дэх: “гуйлгачин”, “эр” гэх үйлийн эзэд нь ядуу тарчгийн зовлонд унасан дорд ардыг илтгэж байна. Ядуу хүн ямагт баяны харьяанд байж, хамаг хүчир ажлыг гүйцэтгэдэг ч тун бага хөлс авдгаа өөрөө ч мэдэлгүй зүтгэн амьдардгийг илэрхийлсэн зүйрлэл юм. Энэхүү зүйрлэлийн утга санааг сонссоны дараа ойлгож ухамсарлах ач холбогдол нь: биеэн засаад, гэрээ зас, гэрээ засаад төрөө зас хэмээх зүйр үг, төрийн төлөө огтоно боож үхнэ гэгч хэмээх зүйрлэлийг санагдуулна. Харин үүний эсрэг утга санаа бүхий

зарим зүйр үгэнд нийгмийн дунд баянаасаа ядуу нь олонх болсон ард түмнийг зөвтгөн зүйрлэсэж хэлсэн зүйрлэлүүд нь тоймгүй олон бий. Тухайлбал: “Ядуугийн босгонд эрхэм хүү төрнө, Сул гэрээс гүн эрдэмтэн гарна” гэдэг зүйр үгийг ядуу айлаас эрхэм дээдэс ч төрдөг гэсэн өөдрөг сэтгэмж.” хэмээн тайлжээ. Монголчууд эд хөрөнгийг угаас шүтдэггүй, эд хөрөнгө мөнх биш үрэгдэж дуусна гэж сургамжилдаг ба баян хүнийг машид бардам сэтгэлтэй, дээрэнгүй, ашигч, худалч, бялдууч, тэнэг, хийрхүү гэж зүйрлэдэг. Зүйр цэцэн үг ААЗ-ын нэг төрөл учраас массын үзэл, үнэт зүйл туссан байдаг. Мөн бидэнд аман ба бичгээр уламжлагдан ирсэн зүйр цэцэн үгсэд зориг, санаа, арга мэх зэргийг илтгэсэн зүйр үгсүүд олонтой байдаг. “Зоригоор ялна, Сургаар олно” гэдэг зүйр үг: “Зоригоор зовлон олно, Зоосоор шүдлэн олно” гэдэг үгтэй хэлбэрийн хувьд ижил байна. “Ялна”, “зовлон олно” хэмээх эсрэгцэл бүхий үгс нэг байранд тохиолдож, эсрэг утга илэрхийлсэн. “сургаар олно”, “зоосоор шүдлэн олно” гэсэн шүлэглэл нь эхний мөрөн дэхтэй яг адил. Харин эхний зүйр үгэнд олох зүйл хураагдсан байгаа нь монголчуудын өдөр тутмын эрхэлдэг ажил мал аж ахуй, нүүдэллэж амьдардагтай холбогдоно. Таван хошуу малаас өөр хайх зүйл тун ховор учир “мал” гэж цохон нэрлэх шаардлага байхгүй байжээ. Мөн эр зориг, арга мэх, ухаан байхад хүчрэхгүй зүйл үгүй гэсэн утгатай:

“Арга байвал арслан барина

Зориг байвал барс барина” зүйр үг. Үүнтэй утга эсрэгцүүлсэн өөрийн хэрээс хэтэрсэн зүйлээс дөлж, амиа авч гарахыг хэлсэн” ((. Ням-Осор, Б. Өлзийсүрэн. 2011. х- 19) утга бүхий:

“Айвал аминд тустай

Зайлбал зам ихтэй” гэдэг зүйр үг бий. Эхний зүйр үгэнд эерэг үнэлэмж илэрч буй мэт боловч “тэнэг хүн зоригтой” гэсэнтэй адил далд утга байхад удаах зүйр үгэнд “уснаас хуурай гарч ирэх” арга самбаатай хүнийг зүйрлэж байж болох юм. Хэлэх гэсэн санаагаа эсрэг утгатай үгээр нь илэрхийлсэн: “Айвал арга тасрах, Ичвэл хэл тасрах” хэмээх үг нь “айвал, ичвэл” хэмээх үгээр зоригийн мөн чанарын тухай өгүүлжээ. Энэ мэт сэтгэхүйн янз бүрийн аргыг ашиглан, эсрэг утгатай зүйр үгийг бүтээдэг ажээ. Энэ мэт зүйр үгсийн хэл найруулга, утга агуулгыг нягтлан үзвээс: нэг утга санааг илтгэсэн зүйр үгсэд хариу үйлдэл үзүүлэгч эсрэг утгат зүйр үгсийн шүлэглэл нь тухайн зүйр үгсийн үндсэн утгыг өөрчлөгч тэс ондоо зүйлс бус хэлний эсрэг утгыг илэрхийлэх хэвшмэл зүйр үг юм уу? Үндсэн утгыг эсрэгээр гуйвуулан мушгин тайлбарласан шинжтэй зүйр үгс байдаг байна.

Дүгнэлт

Тухайн хүний оюун санаа, сэтгэлийн туршлагын үр дүнд бий болсон субъективизмийн үр дүн нь даруй зүйр цэцэн үг юм.

Сэтгэлгээний эсрэг утга нь амьдралын туршлагаас үүдэн бий болж, хэл хэлэхүйн харьцаагаар дамжин бусад сонсогчдын чихнээ хүрч санаа зөвлөмж, зөвлөгөө болж, үргэлж ахин дахин давтагдан хэлэгдэх учир хэвшсэн шүлэглэлт зүйр цэцэн үгийг бий болгодог.

Ертөнц тэр чигээрээ сайн-муу, сайхан-муухай, таатай-таагүй, зохистой-зохисгүй гэх мэт хоёр туулийн дунд орчиж байдаг учир утга эсрэгцэх сэтгэлгээ хүмүүний оюун санааны анхдагч сэдэл болж, өөрийн үнэт зүйлсийнхээ шалгуураар шүүн тунгаасны эцэст эвлэрэл болоод эсрэгцлийн бодол санаа үүсгэдэг.

Утга эсрэгцэх зүйр үг нь: амьдралаас амсан эдэлсэн зовлон жаргалын үр дүнгийн тодорхойлол томъёолол шинжтэй уран яруу шүлэглэлт зөвлөгөө болж байдаг байна.

Ном зүй

- Д. Батбаяр. (2011). Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц. Улаанбаатар
 Ж. Баянсан Ш. Одонтөр. (2004) “Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. Улаанбаатар
 Ж. Баянсан. (2002) Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ. Улаанбаатар
 Н. Ням-Осор, Б. Өлзийсүрэн (2011). Монгол хэлний зүйр, цэцэн үгийн товч тайлбар толь. Улаанбаатар
 Э.Равдан. (2000). Орчин цагийн хэл шинжлэлийн үүд. Улаанбаатар
 Ц. Өлзийхутаг. (1979). Монгол хэлний үгсийн сан судлал. Улсын хэвлэх үйлдвэр
 К. Г. Юнг. (2011). Бэлгэдэлт амьдрал. Улаанбаатар
 С. Энхбаяр. (2008). Утга зохиолын онол. Улаанбаатар

Study on “contradicting proverbs

*Na Ren Ge Ri Le,
 Hohhot National Experimental School, Inner Mongolia Autonomous Region*

Abstract

It is impossible to express the meaning of proverbs with only a single context and immobility so that depending on an individual's unequal life experiences from one another, their perspectives to life vary. Meaning of the many in the universe exists on an unequal correlation of good and bad, nice and mean, black and white, right and wrong, and true and false. The evidence to prove them true or false doesn't have to be the same, like the absolute opposites. The linguistics for expressing these two meanings and interpretations is referred to as “contradictory proverbs”. Because contradictory proverbs serve as the optimal advisory logical meaning for one's and others' life incidents and reasonings, this paper is written with the purpose of realizing the meaning of the contradictory proverbs, cause for its origin, and presenting the study results about methodologies of understanding the style forms such as poetics.

Keyword

Value antonyms, values, language, culture, and proverb